

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/91/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас:260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас:261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох
Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.22 № 04/772

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн олон жилийн насжилттай сургалтын төлбөрийн авлага болон урьдчилж орсон орлогыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй, орлогоор бүртгэх, буцааж олгох эсэхийг шийдвэрлээгүй зэрэг нийт 2,745.5 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон 669.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх”, “эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Шинжлэх ухаан технологийн их сургууль нь ерөнхий боловсролын гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн анхан шатны сургалт, дипломын, бакалавр, магистр, докторын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах үйл ажиллагаа явуулж байна.

Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 06 дугаар тогтоолоор “Сургуулийн бүтэц шинэчлэн батлах” тогтоолоор захиргааны нэгжүүдийн чиг үүрэг, орон тоог шинэчлэн баталсан байна. Тогтоолын дагуу Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захиргаа нь 5 дэд захирал, 5 газар, 16 алба, төв бүхий бүтцээс 3 газар, 16 алба, 4 нэгж бүхий зохион байгуулалттай болж өөрчлөгдсөн, 2023 онд шинэчилсэн бүтэц орон тооны дагуу ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлан хугацаанд БШУЯ-ны харьяа Боловсролын ерөнхий газраас Механик тээврийн сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн мэргэжлийн анхан шатны сургалтад 484.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн ахлах сургууль, Шинжлэх ухаан технологийн ерөнхий боловсролын ахлах сургуулийн сургалтад 176.6 сая төгрөг, Инженер технологийн дээд боловсролыг шинэчлэх төслөөс 78.0 сая төгрөг, Шинжлэх ухаан технологийн сангаас 623.6 сая төгрөг, Боловсролын зээлийн сангаас буцалтгүй тусламжийн санхүүжилт 1,063.8 сая төгрөг, Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагч гадаад оюутны сургалтын төлбөр, тэтгэлгийн 17.1 сая төгрөг, Оюутны унааны зардлын 107.0 сая төгрөг, Оюутны хөгжлийн зээлийн 899.5 сая төгрөг, орон нутгийн суралцагчдын сургалтын төлбөрийн 50.0 хувь 634.2 сая төгрөг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн 524.9 сая төгрөг, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийн 200.0 сая төгрөг, нийт 4,809.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 4,642.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|--------------|--|---------------------------|---------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 30,243,981,289.54 | 33,712,660,817.35 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 23,779,464,571.24 | 28,247,503,142.31 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 20,360,136,156.17 | 20,085,385,555.84 |
| 3121 | Төгрөг | 19,960,497,108.77 | 19,876,478,201.23 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 19,960,497,108.77 | 19,876,478,201.23 |
| 3122 | Гадаад валют | 399,639,047.40 | 208,907,354.61 |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 399,639,047.40 | 208,907,354.61 |
| 314 | Замд яваа мөнгөн хөрөнгө | 27,562,028.50 | 380,525,583.00 |
| 315 | Хадгаламж | 3,391,766,386.57 | 7,781,592,003.47 |
| 33 | АВЛАГА | 3,252,390,252.42 | 3,174,238,731.97 |
| 332 | Төлбөртэй ажил, үйлчилгээний авлага | 2,367,345,256.72 | 2,367,900,679.64 |
| 33210 | Сургалтын төлбөрийн авлага | 2,367,345,256.72 | 2,367,900,679.64 |
| 335 | Бусад авлага | 885,044,995.70 | 806,338,052.33 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 677,879,543.73 | 578,029,257.46 |
| 33520 | Хүмүүсээс авах авлага | 207,165,451.97 | 228,308,794.87 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 899,987,492.78 | 338,522,112.53 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 89,667,510.00 | 67,089,080.00 |
| 347 | Урьдчилгаа тооцоо | 810,319,982.78 | 271,433,032.53 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 334,821,328.00 | 155,597,516.68 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 475,498,654.78 | 112,312,108.85 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | - | 2,540,400.00 |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | - | 983,007.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,312,138,973.10 | 1,952,396,830.54 |
| 351 | Түүхий эд материал | 1,768,208,399.75 | 1,446,672,009.96 |
| 35110 | Тусгай зориулалтын материал | 1,765,736,212.20 | 1,443,093,991.96 |
| 35130 | Эм боох материал | 2,472,187.55 | 3,578,018.00 |
| 353 | Бэлэн бүтээгдэхүүн | 53,133,088.76 | 52,330,427.54 |
| 354 | Хангамжийн материал | 490,797,484.59 | 453,394,393.04 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 187,396,174.29 | 191,332,235.23 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,703,864.70 | 40,597,815.32 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 7,589,690.00 | 5,527,379.00 |
| 35440 | Түлш, шатах, тослох материал | 300,000.00 | 150,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 13,038,503.92 | 22,990,623.92 |
| 35460 | Хүнсний материал | 9,804,238.63 | 5,412,088.96 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 222,965,013.05 | 187,384,250.61 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 133,882,126,382.28 | 131,023,693,206.87 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 133,882,126,382.28 | 131,023,693,206.87 |
| 392 | Биет хөрөнгө | 125,550,368,968.51 | 119,040,654,071.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 90,764,130,909.37 | 91,596,388,698.77 |
| 39202 | Барилга, байгууламж, орон сууцны хуримтлагдсан элэгдэл | (12,893,294,354.75) | (16,475,253,908.06) |

**Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

| | | | |
|------------|--|---------------------------|---------------------------|
| 39203 | Авто - тээврийн хэрэгсэл | 767,348,317.71 | 727,348,317.71 |
| 39204 | Авто - тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл | (450,047,109.09) | (570,812,587.21) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж (компьютер) | 64,515,457,914.53 | 70,575,851,467.45 |
| 39206 | Машин, тоног төхөөрөмж (компьютер)-ийн хуримтлагдсан элэгдэл | (23,227,124,074.48) | (32,734,785,132.25) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5,855,535,541.69 | 6,155,139,661.09 |
| 39208 | Тавилга, аж ахуйн эд хогшлын хуримтлагдсан элэгдэл | (3,250,852,056.74) | (3,771,450,092.05) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйл | 128,415,550.00 | 128,415,550.00 |
| 39214 | Бусад хөрөнгө | 238,331,788.75 | 238,431,950.75 |
| 39215 | Бусад хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл | (126,808,228.80) | (148,077,439.95) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 525,079,198.55 | 525,079,198.55 |
| 39217 | Ном | 2,704,195,571.77 | 2,794,378,386.35 |
| 393 | Биет бус хөрөнгө | 8,331,757,413.77 | 11,983,039,135.72 |
| 39301 | Программ хангамж | 1,650,622,407.86 | 5,873,650,223.46 |
| 39302 | Программ хангамжийн хуримтлагдсан элэгдэл | (870,375,934.09) | (1,442,122,027.74) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,551,510,940.00 | 7,551,510,940.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 164,126,107,671.82 | 164,736,354,024.22 |
| 4 | ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 12,040,404,353.08 | 14,452,562,995.63 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 11,993,186,879.78 | 14,410,315,785.13 |
| 413 | Өглөг | 435,813,105.94 | 591,587,156.38 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 798,097.00 | 10,062,018.12 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 435,015,008.94 | 581,525,138.26 |
| 414 | Урьдчилж орсон орлого | 11,557,373,773.84 | 13,818,728,628.75 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 11,557,373,773.84 | 13,818,728,628.75 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР | 47,217,473.30 | 42,247,210.50 |
| 422 | Урт хугацаат зээл | 47,217,473.30 | 42,247,210.50 |
| 42224 | Төслийн зээл | 47,217,473.30 | 42,247,210.50 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 152,085,703,318.74 | 150,283,791,028.59 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 152,085,703,318.74 | 150,283,791,028.59 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 30,687,495,579.44 | 30,687,495,579.44 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 30,687,495,579.44 | 30,687,495,579.44 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 60,297,390,980.70 | 58,495,478,690.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 51,020,507,310.61 | 60,251,722,413.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 9,276,883,670.09 | (1,756,243,722.67) |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 61,100,816,758.60 | 61,100,816,758.60 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 164,126,107,671.82 | 164,736,354,024.22 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 76,239,610,343.40 | 78,418,162,608.19 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 76,239,610,343.40 | 78,418,162,608.19 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 76,239,610,343.40 | 78,418,162,608.19 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 76,239,610,343.40 | 78,418,162,608.19 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 71,926,221,995.71 | 73,507,591,872.10 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,313,388,347.69 | 4,910,570,736.09 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 66,721,226,701.08 | 80,057,686,359.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 66,721,226,701.08 | 80,057,686,359.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 65,830,347,917.42 | 79,054,480,109.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 36,142,240,396.34 | 42,041,086,086.41 |
| 210101 | Үндсэн цалин | 29,267,689,202.87 | 33,889,739,458.92 |
| 210102 | Нэмэгдэл | 6,874,551,193.47 | 8,151,346,627.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,535,791,849.53 | 5,276,735,407.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,106,640,875.44 | 3,628,340,864.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 376,139,019.19 | 435,083,961.66 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 291,364,835.48 | 336,639,813.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 67,384,314.47 | 80,529,457.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 694,262,804.95 | 796,141,310.82 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,405,740,582.88 | 1,857,924,917.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 582,228,797.31 | 797,490,751.42 |
| 210302 | Түлш, халаалт | 532,873,476.10 | 740,337,969.81 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 290,638,309.47 | 320,096,196.35 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 495,048,238.84 | 512,758,623.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 71,280,843.90 | 88,269,701.75 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,849,717.31 | 13,394,262.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 24,246,215.01 | 17,763,526.67 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,498,526.14 | 80,414,430.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 26,698,913.00 | 32,367,334.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 238,474,023.48 | 280,549,368.92 |
| 2105 | Нормативд зардал | 100,602,315.95 | 119,867,510.48 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,778,652.95 | 16,429,467.48 |
| 210502 | Хоол, хүнс | 24,874,360.00 | 39,111,490.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 57,949,303.00 | 64,326,553.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 699,239,884.33 | 1,047,163,479.50 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 358,500.00 | - |
| 210602 | Тавилга | 4,531,000.00 | 19,855,950.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 34,282,964.00 | 41,241,605.00 |
| 210604 | Урсгал засвар | 660,067,420.33 | 986,065,924.50 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 103,281,531.00 | 166,401,313.90 |
| 210701 | Гадаад албан томилолт | 22,133,201.00 | 83,284,005.90 |
| 210702 | Дотоод албан томилолт | 63,528,585.00 | 46,026,236.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 17,619,745.00 | 37,091,072.00 |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|--------------------------|---------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,055,274,705.12 | 2,782,134,025.38 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,959,534,189.85 | 2,611,086,251.52 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 206,500.00 | 41,763,294.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 358,080.00 | 1,062,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 8,836,321.00 | 20,281,717.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,888,543.00 | 1,142,120.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 63,658,920.18 | 76,137,287.93 |
| 210807 | Газрын төлбөр | 15,954,724.00 | 21,165,096.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 4,837,427.09 | 9,495,308.93 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,293,128,413.43 | 25,250,408,744.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 805,308,998.34 | 955,900,280.86 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,848,860,659.28 | 7,768,942,596.99 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,638,958,755.81 | 16,525,565,866.97 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 890,878,783.66 | 1,003,206,250.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 890,878,783.66 | 1,003,206,250.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 11,400,000.00 | 46,122,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 698,015,782.00 | 582,046,830.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 181,463,001.66 | 375,036,920.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 9,518,383,642.32 | (1,639,523,751.54) |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 241,499,972.23 | 116,719,971.13 |
| 225002 | Найдваргүй авлагын алдагдал | 5,601,107.80 | 9,582,653.00 |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 18,364,166.35 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 235,898,864.43 | 88,773,151.78 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 9,276,883,670.09 | (1,756,243,722.67) |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|--------------------------|--------------------------|--|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 30,567,495,579.44 | 61,106,329,656.51 | 51,047,275,924.42 | 142,721,101,160.37 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (32,281,511.72) | (32,281,511.72) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 30,567,495,579.44 | 61,106,329,656.51 | 51,014,994,412.70 | 142,688,819,648.65 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 120,000,000.00 | (5,512,897.91) | - | 114,487,102.09 |
| 5 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | 5,512,897.91 | 5,512,897.91 |
| 6 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 9,276,883,670.09 | 9,276,883,670.09 |
| 7 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 30,687,495,579.44 | 61,100,816,758.60 | 60,297,390,980.70 | 152,085,703,318.74 |
| 8 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (45,668,567.48) | (45,668,567.48) |
| 9 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 30,687,495,579.44 | 61,100,816,758.60 | 60,251,722,413.22 | 152,040,034,751.26 |
| 10 | Тайлант үеийн үр дүн | - | - | (1,756,243,722.67) | (1,756,243,722.67) |
| 11 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 30,687,495,579.44 | 61,100,816,758.60 | 58,495,478,690.55 | 150,283,791,028.59 |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 64,748,927,488.45 | 76,973,482,468.30 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 64,748,927,488.45 | 76,973,482,468.30 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 64,748,927,488.45 | 76,973,482,468.30 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 64,748,927,488.45 | 76,973,482,468.30 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 57,876,464,792.08 | 67,856,678,039.97 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,872,462,696.37 | 9,116,804,428.33 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 59,841,340,712.79 | 68,762,663,095.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 59,841,340,712.79 | 68,762,663,095.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 58,912,792,487.13 | 67,760,835,091.88 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 36,143,828,759.34 | 42,031,771,922.23 |
| 210101 | Үндсэн цалин | 29,269,277,565.87 | 33,880,425,294.74 |
| 210102 | Нэмэгдэл | 6,874,551,193.47 | 8,151,346,627.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,534,548,944.14 | 5,273,859,553.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,066,240,462.85 | 3,626,527,481.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 423,008,841.65 | 434,796,653.66 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 281,571,020.42 | 336,409,975.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 65,220,782.47 | 80,491,078.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 698,507,836.75 | 795,634,363.82 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,407,838,047.88 | 1,790,787,843.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 587,984,330.31 | 808,854,397.38 |
| 210302 | Түлш, халаалт | 532,893,576.10 | 659,786,216.05 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 286,960,141.47 | 322,147,230.55 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 437,512,706.32 | 423,442,905.26 |
| 210401 | Бичиг хэрэг | 51,062,316.00 | 56,104,446.18 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,608,167.31 | 7,844,075.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 25,131,715.01 | 17,906,536.67 |
| 210404 | Ном, хэвлэл | 77,513,162.00 | 50,876,890.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 26,348,913.00 | 34,367,334.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 222,848,433.00 | 256,343,623.00 |
| 2105 | Нормативд зардал | 100,572,501.83 | 119,709,150.93 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,587,710.50 | 12,945,407.93 |
| 210502 | Хоол, хүнс | 24,014,760.00 | 35,722,240.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 59,970,031.33 | 71,041,503.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 690,476,313.97 | 899,808,523.20 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,269,600.00 | - |
| 210602 | Тавилга | 2,379,200.00 | 7,017,844.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 35,008,277.00 | 48,166,585.00 |
| 210604 | Урсгал засвар | 651,819,236.97 | 844,624,094.20 |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|---------------------------|---------------------------|
| 2107 | Томилолт, зочны зардал | 98,155,461.00 | 163,825,685.90 |
| 210701 | Гадаад албан томилолт | 22,126,321.00 | 89,820,453.90 |
| 210702 | Дотоод албан томилолт | 61,439,935.00 | 44,271,831.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 14,589,205.00 | 29,733,401.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,915,741,394.54 | 8,706,512,083.02 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,820,463,130.67 | 8,510,436,461.56 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,118,300.00 | 51,197,713.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 358,080.00 | 562,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 5,944,721.00 | 5,993,727.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 2,953,543.00 | 2,015,110.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 63,243,681.18 | 104,790,628.93 |
| 210807 | Газрын төлбөр | 15,954,724.00 | 21,165,096.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 5,705,214.69 | 10,350,396.53 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,584,118,358.11 | 8,351,117,423.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 714,329,352.03 | 876,512,192.38 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,869,789,006.08 | 7,474,605,231.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 928,548,225.66 | 1,001,828,004.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 928,548,225.66 | 1,001,828,004.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 11,400,000.00 | 46,122,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 730,590,324.00 | 661,501,829.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 186,557,901.66 | 294,203,675.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 4,907,586,775.66 | 8,210,819,372.42 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 5,913,237,066.10 | 3,724,416,635.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,913,237,066.10 | 3,724,416,635.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 5,913,237,066.10 | 3,724,416,635.00 |
| 220001 | Барилга байгууламж | 26,760,251.29 | 265,066,453.87 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 446,077,041.93 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 10,640,250.00 | 82,280,950.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,429,759,522.88 | 3,377,069,231.13 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (5,913,237,066.10) | (3,724,416,635.00) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | - | (18,364,166.35) |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | - | 18,364,166.35 |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 18,364,166.35 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (1,005,650,290.44) | 4,468,038,571.07 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 24,785,114,861.68 | 23,779,464,571.24 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 23,779,464,571.24 | 28,247,503,142.31 |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | 2022 оны гүйцэтгэл | 2023 он | | Зөрүү | Хувь |
|--|---------------------------|---------------------------|--------------------------|-------------------------|-------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН НИЙТ ОРЛОГЫН ДҮН | 59,442,927,976.70 | 65,227,911,700.00 | 70,869,652,948.95 | 5,641,741,248.95 | 108.6 |
| Хүүгийн орлого | 314,460,798.35 | 30,000,000.00 | 1,359,009,445.65 | 1,329,009,445.65 | 4,530.0 |
| Сургалтын төлбөрийн орлого | 45,483,455,659.01 | 49,480,972,600.00 | 55,106,301,606.59 | 5,625,329,006.59 | 111.4 |
| Боловсролын зээлийн сангийн орлого | 1,420,157,721.20 | 1,700,000,000.00 | 1,715,150,043.56 | 15,150,043.56 | 100.9 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 9,034,200,712.37 | 13,054,543,900.00 | 10,395,629,221.09 | (2,658,914,678.91) | 79.6 |
| Тусламжийн орлого | 1,737,764,199.70 | 166,382,300.00 | 816,108,657.00 | 649,726,357.00 | 490.5 |
| Төсвийн санхүүжилтийн орлого | 1,401,046,658.29 | 796,012,900.00 | 1,469,931,736.76 | 673,918,836.76 | 184.7 |
| Татварын бус бусад орлого, олз | 51,842,227.78 | - | 7,522,238.30 | 7,522,238.30 | 100.0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 60,448,578,267.14 | 71,933,470,800.00 | 66,401,614,377.88 | 5,531,856,422.12 | 92.3 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 36,143,828,759.34 | 43,710,695,600.00 | 42,031,771,922.23 | 1,678,923,677.77 | 96.2 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,534,548,944.14 | 5,463,836,900.00 | 5,273,859,553.38 | 189,977,346.62 | 96.5 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,407,838,047.88 | 2,315,826,000.00 | 1,790,787,843.98 | 525,038,156.02 | 77.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 577,896,759.57 | 652,694,400.00 | 538,975,922.62 | 113,718,477.38 | 82.6 |
| Нормативд зардал | 100,572,501.83 | 170,556,800.00 | 120,689,250.93 | 49,867,549.07 | 70.8 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 1,200,701,751.97 | 1,669,972,900.00 | 1,248,277,509.60 | 421,695,390.40 | 74.7 |
| Томилголт, гадаад зочны зардал | 98,155,461.00 | 191,990,500.00 | 163,825,685.90 | 28,164,814.10 | 85.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,467,883,262.79 | 3,124,178,000.00 | 2,485,420,187.62 | 638,757,812.38 | 79.6 |
| Бараа, үйлчилгээний бусад зардал | 9,181,366,659.74 | 11,609,093,100.00 | 9,982,040,469.75 | 1,627,052,630.25 | 86.0 |
| Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 928,548,225.66 | 1,163,726,600.00 | 1,001,828,004.00 | 161,898,596.00 | 86.1 |
| Өөрийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалт | 3,807,237,893.22 | 1,860,900,000.00 | 1,764,138,027.87 | 96,761,972.13 | 94.8 |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (1,005,650,290.44) | (6,705,559,100.00) | 4,468,038,571.07 | 109,884,826.83 | |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 24,785,114,861.68 | x | 23,779,464,571.24 | | |
| Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл | 23,779,464,571.24 | x | 28,247,503,142.31 | | |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 1,916 | 1,960 | 1,929 | 31 | 98.4 |
| Удирдах ажилтан | 4 | 4 | 4 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 1,173 | 1,222 | 1,116 | 106 | 91.3 |
| Үйлчилгээний ажилтан | 388 | 408 | 382 | 26 | 93.6 |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|---------------------|--------|--------|--------|-------|-------|
| Гэрээт, цагийн багш | 351 | 326 | 427 | (101) | 131.0 |
| ОЮУТНЫ ТОО | 15,391 | 15,625 | 15,598 | 27 | 99.8 |
| Диплом | 40 | - | 30 | 30 | 100.0 |
| Бакалавр | 12,622 | 12,963 | 12,750 | (213) | 98.4 |
| Магистр | 1,219 | 1,123 | 1,117 | (6) | 99.5 |
| Доктор | 130 | 159 | 167 | 8 | 105.0 |
| МСҮТ | 801 | 670 | 816 | 146 | 121.8 |
| Ахлах сургууль | 579 | 710 | 718 | 8 | 101.1 |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар илэрсэн 293.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|------------|-----------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----------|---------|-----------|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ШУТИС-ийн үйлдвэрлэлийн технологи, судалгаа инновацийн барилгын өөрчлөлтийн зураг төслийн зардлыг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн. | 1 | 279,023.9 | | | | | | | 1 | 279,023.9 | 1 | 279,023.9 |
| 2 | Бусад төлбөр, хураамж татварын зардал дансанд 14,700.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын зардлыг бүртгэсэн байна. | 1 | 14,700.0 | | | | | | | 1 | 14,700.0 | 1 | 14,700.0 |
| | Дүн | 2 | 293,723.9 | | | | | | | 2 | 293,723.9 | 2 | 293,723.9 |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

3.2. Аудитаар нийт 2,745.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2,745.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|--|-------------|-------------|---------------|-----|-----------------|-------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн | | |
| 1 | Сургалтын төлбөрөөс үүссэн 1,844,850.2 мянган төгрөгийн авлагаас 731,866.8 мянган төгрөгийн авлага нь 6 ба түүнээс дээш жилийн насжилттай, нийт 1385 суралцагчийн барагдуулаагүй авлага байна. Мөн ахлах сургуулиас гарч өөр сургуульд шилжсэн 29 суралцагчийн 40,483.4 мянган төгрөгийн, сургуулиа төгссөн 27 суралцагчийн 60,367.0 мянган төгрөгийн нийт 100,850.4 мянган төгрөгийн 2-7 жилийн насжилттай, авлагыг барагдуулаагүй байна. | 1 | 832,717.2 | | | 1 | 832,717.2 | | | | | | | | |
| 2 | Санхүүгийн тайланд сургалтын төлбөрөөс үүссэн 11,116,150.1 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэй бөгөөд үүнээс ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу дахин суралцах боломжгүй нийт 13,576 суралцагчтай холбоотой 1,912,809.0 мянган төгрөгийн урьдчилж орсон орлогыг шийдвэрлээгүй, тооцоо нийлээгүй байна. | 1 | 1,912,809.0 | | | 1 | 1,912,809.0 | | | | | | | | |
| 3 | Хөрөнгийг сургууль хооронд балансаас баланст шилжүүлэхдээ дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц дансны үлдэгдлийг шилжүүлээгүйгээс салбар сургуулийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц данс алдаатай бүртгэгдэж байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | | | |
| | Дүн | 3 | 2,745,526.2 | - | - | 2 | 2,745,526.2 | 1 | - | - | - | - | - | - | - |

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 408.9 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах албан шаардлага 1 хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|--|-------------|-----------|-----------------|-----|--------------------------------------|-----------|---------|-----|
| | | | | Албан шаардлага | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Тоо | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| <i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i> | | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 57,125,603.5 мянган төгрөгийн дүн бүхий 918 орлогын гүйлгээнээс 389,839.4 мянган төгрөгийн 13 гүйлгээг мэдээлээгүй, 2,105,091.9 мянган төгрөгийн 71 гүйлгээг хугацаа хоцроосон, 48,586,427.8 мянган төгрөгийн дүн бүхий 872 зардлын гүйлгээнээс 19,027.9 төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй, 6,136,708.2 мянган төгрөгийн 76 гүйлгээг хугацаа хоцроон тайлагнасан байна. | 1 | 408,867.3 | | | 1 | 408,867.3 | | |
| <i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i> | | | | | | | | | |
| 2 | Тус сургуулийн мөрдөж буй сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам болон санхүүгийн үйл ажиллагааны журмуудад сургуулиас гарсан, шилжсэн, төгссөн, сураггүй болсон оюутнуудтай хэрхэн сургалтын төлбөрийн тооцоо хийх талаар тусгаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| 3 | Худалдан авах ажиллагаатай холбоотой сонгон шалгаруулалтын материалаас түүвэрлэн үзэхэд ШУТИС/202305051 кодтой тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийн он сар өдөр цахим тендерийн он сар өдрөөс зөрсөн, үнэлгээний хорооны шийдвэрт компанийн нэр зөрүүтэй байна. | 1 | - | 1 | - | | | | |
| | Нийт дүн | 3 | 408,867.3 | 1 | - | 1 | 408,867.3 | 1 | - |